



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын багцын 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон нийт 19 нэрийн 35,288,113.027.00 (гучин таван тэрбум хоёр зуун наян найман сая нэг зуун арван гурван мянга хорин долоон) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу холбогдох аймаг, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн хэлтсийн дарга Л.Цэдэвсүрэн, Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын дарга Ш.Үнэнбат, Архангай, Баян-Өлгий, Увс, Дундговь, Завхан, Хэнтий, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэл, аймагт бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА:

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 1-ны өдрийн
2020 оны 2 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Нийт өртөг /тегрөгөөр/	Ашиглалтад орсон он, сар, өдөр, актын дугаар	Бүртгэж авах хуулийн этгээд, нийслэл, аймгийн нэр
1	Сургуулийн өвлийн спортын талбай /Увс, Улаангом сум, 4 дугаар сургууль/	97,195,241.00	2019.09.30 № 34	Увс (Улаангом сум)
2	Сургуулийн өвлийн спортын талбай /Увс, Улаангом сум, 6 дугаар сургууль/	99,552,447.00	2019.12.25 № 66	Увс (Улаангом сум)
3	Сургуулийн спорт заалын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, 9 дүгээр сургууль/	968,400,000.00	2019.12.25 №2019/153	Улаанбаатар, (Сонгинохайрхан дүүрэг)
4	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Баянжаргалан сум/	950,651,751.00	2019.09.13 №18/2019	Дундговь(Баянжаргалан сум)
5	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Завхан, Алдархаан сум/	676,199,644.00	2019.08.19 №18/2019	Завхан (Алдархаан сум)
6	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хэнтий, Дэлгэрхаан сум/	1,424,088,853.00	2019.12.10 №65/2019	Хэнтий (Дэлгэрхаан сум)
7	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум/	389,083,870.00	2019.11.21 №31/2019	Баян-Өлгий (Ногооннуур сум)
8	Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/	1,965,960,891.00	2019.10.23 №2019/497	Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг)
9	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 62 дугаар цэцэрлэг/	1,879,041,508.00	2019.10.04 №2019/413	Улаанбаатар (Баянзүрх дүүрэг)
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	1,903,318,816.00	2019.12.10 №БУ-79/2019	Сэлэнгэ (Цагааннуур сум)
11	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/	1,453,607,619.00	2019.09.16 №2019/365	Улаанбаатар, (Сонгинохайрхан дүүрэг)
12	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Налайх дүүрэг, 1 дүгээр хороо/	1,500,000,000.00	2019.10.10 №2019/447	Улаанбаатар (Налайх дүүрэг)
13	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/	18,900,000.00	2016.11.15 №бу-2016/193	Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг)
14	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Шилүүстэй сум/	754,484,664.00	2019.12.13 №55/2019	Завхан (Шилүүстэй сум)
15	"Хархираагийн соёл" түүхийн төвийн барилга /Дорнод, Баян Уул/	243,900,000.00	2018.12.20 №2018/07	Дорнод (Баян -Уул)
16	Баруун монголын уламжлалт соёлын төв /Увс, Улаангом/	3,406,200,000.00	2019.12.21 №61	Увс (Улаангом сум)
17	Төв Монголын байгаль-түүх соёлын цогцолбор ТЭЗҮ	171,000,000.00	2019.06.10 №ХАТ17/18	Архангай (Эрдэнэбулган сум)
18	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал, /Улаанбаатар, Чингэлтэй/	13,627,776,265.00	2020.03.10 №2020/163	Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг)
19	Усан бассейн барилга, 400 суудал /Сүхбаатар, Баруун урт/	3,758,751,458.00	2018.10.01 №СҮ-008/18	Сүхбаатар (Баруун урт, Биеийн тамир спортын газарт)
		35,288,113,027.00		
	Нийт дүн	(гучин таван тэрбум хоёр зуун наян найман сая нэг зуун арван гурван мянга хорин долоо)		